



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.02 № 1377

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Н.ГАН-ОД
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн Нямдоржийн Ган-Одын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Нямдоржийн Ган-Одын нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн


Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Нямдоржийн Ган-Одын мөрийн хөтөлбөр / 3 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 3 хуудастай


ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



2020 оны Орон нутгийн сонгуульд
Нийслэлийн

Хан-Уул дүүргийн 15-р хороонд бие даан
нэр дэвшигч **Нямдорж** овогтой **Ган-Одын**
мөрийн хөтөлбөр.

1. Нийслэл, сум дүүргийн түвшинд үзүүлэх төрийн үйлчилгээг тодорхойлж, шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсролын тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлэхийн төлөө ажиллана. Цахим ардчиллыг хөгжүүлж, орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох боломжийг бүрдүүлнэ. Хувийн хэвшлийн технологийн хөгжүүлэлтийг дэмжинэ. Аж үйлдвэр, үйлчилгээний салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.
2. Авилга албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах, авилгалаас урьдчилан сэргийлэхэд орон нутаг, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Орон нутгийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээн суурилсан, түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх, иргэн төвтэй үйлчилгээний стандарт боловсруулна. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлд анхаарч ажиллана. Орон нутгийн албан хаагчийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, ажлын дүнгээс хамаарч шатлан дэвших зорилтыг боловсронгуй болгоно.
3. Хүн бүр чанартай боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, нийгмийн халамжинд хамрагдах, хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлэхийн төлөө ажиллана. Сургуулийн өмнөх боловсрол, бага сургууль нь хүүхдийн төлөвшлийн суурь гэж үзэж хүүхдийн цэцэрлэг болон бага сургуулийн сургалтыг дэмжиж 'Эх оронч Монгол хүүхэд' сургалтын хөтөлбөр санаачилна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд зориулсан орчинг бүрдүүлэхэд тэдэнд ээлтэй дүүрэг байхад чиглэсэн бүх талын ажлыг дэмжиж ажиллана. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр идэвхитэй ажиллана. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож гэр бүлийн гишүүн бүрт хүрэх нийгмийн бодлого, зорилтот бүлэгт үзүүлэх халамж, дэмжлэгийг хүртээмжтэй болгоход анхаарч ажиллана.
4. Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн хөгжлийн хэрэгцээг түлхүү анхаарч ажиллана.



Д.Мун


түгжрэл, нийтийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжгүй байдал зэрэг олон асуудлыг шийдэхэд дэмжиж ажиллана. Хотын нэгдсэн стандарттай болгож иргэдийн оролцоотой, иргэн төвтэй болгох нөхцлийг бүрдүүлнэ. Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж агаар болон хөрсний бохирдлыг бууруулахыг зорьж ажиллана. Хог хаягдлыг дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах, ялгах хэвшлийг хэвшүүлэх зорилт тавьж ажиллана.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15-р хорооны иргэн

..... *Н.О.О* /Гарын үсэг/

Нямдорж овогтой Ган-Од



Н.О.О